БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА П.ЭРХЭМБУЛГАН

**НИЙСЛЭЛ ДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗӨӨЛӨН ЭДЛЭЛ, ЦАГААН ХЭРЭГЛЭЛИЙГ АРИУТГАХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

| Ажлын нэр төрөл | Тайлбар |
|---|---|
| **Ажил гүйцэтгэх үндэслэл** | Нийслэлийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагын дотоод орчны агаар дусал, бусад замаар вирус, нян бактерийн халдварын тархалтыг зогсоох, бууруулах, өвчлөлийг багасгах, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагын зөөлөн эдлэл, цагаан хэрэглэлд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх. |
| **Захиалагч байгууллага** | **Нийслэлийн Эрүүл мэндийн газар** |
| **Төслийн байршил талбайн нэр** | Нийслэлийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагын дотоод халдвараас сэргийлэх, зөөлөн эдлэл, цагаан хэрэглэлийн ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ |
| **Талбайн нэр хэмжээ** | Орчны ариутгал- 89595м2 /талбайн хэмжээ/<br>Орны тоо- 4216<br>Гудасны тоо –8432<br>Хөнжилний тоо – 4216<br>Дэрний тоо - 4216 |
| **Гэрээт газрын зорилго, үр дүн** | Нийслэлийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагын зөөлөн эдлэл, цагаан хэрэглэлийн ариутгал халдваргүйтгэл хийсний үр дүнд эрүүл мэндийн байгууллагын дотоод орчны агаар дусал, бусад замаар тархах вирус, нян бактерийн халдварын тархалтыг зогсоох, бууруулах, өвчлөлийг багасгах, эмнэлгийн дотоод халдвараас сэргийлэх. |
| **Гүйцэтгэх ажил** | рүүл мэндийн байгууллагын дотоод орчин талбайд ариутгал халдваргүйтгэл хийх<br>рүүл мэндийн байгууллагын хэвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний орыг ариутгаж, халдваргүйжүүлэх<br>эвтэн эмчлүүлэх тасгийн өвчтөний гудас, хөнжил, дэрийг ариутгаж халдваргүйжүүлэх |
| **Ажиллах хүч, хүний нөөц** | Ариутгал, халдваргүйтгэлийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй, хугацаа хүчин төгөлдөр байх.<br>-Ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр сүүлийн 3-5 жил үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай.<br>-Тухайн компани нь мэргэжлийн хүний нөөц, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх. |
| **Техникийн шаардлага** | Ариутгал, халдваргүйтэлийн үйлчилгээ эрхлэх байгууллага нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, аюулгүй ажиллагааны технологийн горим бүхий техник ашиглалтын паспорттой ариутгалын төхөөрөмжтэй байна.<br>Химийн найрлага нь trioxygen буюу O3 бусад химийн элемент ороогүй. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх. |

| | |
|---|---|
| | Ариутгал,халдваргүйтгэл нь вирус бактери, мөөгөнцөрийн бүрэн устгаж байгаа нь мэргэжлийн байгууллага, лабораторийн дүгнэлтээр тогтоогдсон байх.<br>Ариутгал, халдваргүйтгэлийн аппарат нь эмнэлгийн орны эргэлтэд тохирсон буюу 14 хоногт 1 удаа гудас матрас халдваргүйжүүлэх боломжтой байх.<br>- Эрүүл зүйн шинжилгээний үр дүнд нотлогдсон байх.<br>- Орчны агаар дахь озоны хэмжээг хэмжих тооцоолох боломжтой буюу озоны халдваргүйтгэлийн үед ажилчдын эрүүл мэндийн сөрөг нөлөө үзүүлэхгүй хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан байх.<br>- Озоны концентрацийг хэмжих багажтай байх. (Зөвшөөрөгдсөн хэмжээ 0.1мг/м3 байлгах)<br>- 1 өдөрт 210 багц ариутгал хийгдэнэ. |
| **Тайлан боловсруулалт** | Гэрээний үүргийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, тайланг бичгээр авна. Албан ёсоор баталгаажсан тайланг хэвлэмэлээр авах ба өрөгтгөлтэй файлаар авна. |
| **Төлбөр тооцоо** | Захиалагч байгууллага гүйцэтгэгч байгууллагад ажлын хөлсийг гэрээний төлбөрийн нөхцөлд заасны дагуу олгоно. |
| **Ажил гүйцэтгэх хугацаа** | Гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 20 хоног байна. |
| **Тайлагнах** | Бүх тайлан материалыг ажлын даалгавар, гэрээний дагуу үйлдэн, чанартай хийж гүйцэтгэн тогтоосон хугацаанд ирүүлнэ.<br>Тайлан нь хийж гүйцэтгэсэн ажлын зураг, тоон мэдээлэлтэй байна.<br>- Төлөвлөгөөний дагуу ажиллаж, явцын тайланг ирүүлж байна.<br>- Тайлангийн ажлын явцад захиалагч талаас хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.<br>**Нэмэлт мэдээлэл.** Захиалагч нь шаардлагатай гэж үзвэл нэмэлтээр хүлээн авах материалд өөрчлөлт оруулах, тайланд засвар оруулах эсэхийг тухай бүрд нь шийднэ. Бүх тайлан, материал, гүйцэтгэлийн зураг, тоон мэдээлэл зэргийг захиалагч байгууллагад ирүүлсэний дараа ажлыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно. |